БАЯН ЖАНЖИН ХИШИГ АУДИТ ХХК

**САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ**

# Тэс сумын Эрүүл мэндийн төвийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

**Аудитын код:** УВА-2026/107/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:
www.audit.mn
Улаангом хот
2026 он

Увс аймаг дахь Төрийн аудитын газар,
Дарга, тэргүүлэх аудитор: М.Батсуурь
Утас: 70453317, Цахим хаяг: BatsuuriM@audit.gov.mn
Аудитын менежер: М.Бат-Амгалан
Утас: 70453799, Цахим хаяг: Bat-Amgalanm@audit.gov.mn
Гэрээгээр аудитыг гүйцэтгэсэн Баян жанжин хишиг аудит ХХК-ийн аудитор: А.Дугармаа
Утас: 99542180, Цахим хаяг: baynjanjinxishig@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА


1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ ..................... **Error! Bookmark not defined.**

Дүгнэлтийн үндэслэл ..................... 3

Асуудлыг онцолсон хэсэг ..................... 3

Аудитын гол асуудал ..................... 3

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ ..................... 5

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА ..................... 13

4.1 Ерөнхий зүйл ..................... 16

4.2 Материаллаг байдал ..................... 17

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал ..................... 17

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт ..................... 17

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал ..................... 18

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ ..................... 18


**Товчилсон үгийн жагсаалт**

| | |
|---|---|
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| СТА | Санхүүгийн тайлангийн аудит |
| БШУЯ | Боловсрол, шинжлэх ухааны яам |
| ТШЗ | Төсвийн шууд захирагч |
| НА | Нийцлийн аудит |

УВС АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
213400, Увс аймаг, Улаангом сум,
Ө.Бадрахын гудамж
Утас: 70-45-33-17, Факс: (976)70-45-33-17,
E-mail: uvs@audit.gov.mn

2026-02-14 №УВА-2026/107/НА-СТА-ТШ3
танай_____________-ны №_______________-т

ТЭС СУМЫН ЭРҮҮЛ МЭНДИЙН
ТӨВИЙН ДАРГА Э.НАНЖИД
ТАНАА

**Өөрчлөлтгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, 8.4, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Тэс сумын Эрүүл мэндийн төвийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Тэс сумын Эрүүл мэндийн төвийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлант жил эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Асуудлыг онцолсон хэсэг**

АДБОУС 2706.7-д тодорхойлсон санхүүгийн тайланд толилуулсан,тодруулсан мэдээлэл байхгүй болно.

**Аудитын гол асуудал**

АДБОУС 2701.8-д тодорхойлсон тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх ажил гүйлгээ байхгүй болно.

**Бусад асуудлын хэсэг**

Санхүүгийн тайлангийн тодруулга толилуулгад тусгаагүй, аудитын хамрах хүрээний хязгаарлалтын улмаас аудитын хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй асуудал гараагүй болно.

8525050491

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР М.БАТСУУРЬ

9065555 1525010041

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

## 2.1. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

*/Төгрөгөөр/*

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **220,332,395.02** | **99,923,499.08** |
| **31** | **МӨНГӨН ХӨРӨНГӨ** | 31,425,060.96 | 92,199.07 |
| **312** | **Банкинд байгаа бэлэн мөнгө** | 31,425,060.96 | 92,199.07 |
| **3121** | **Төгрөг** | 31,425,060.96 | 92,199.07 |
| 31211 | Төрийн сангийн харилцах | 31,425,060.96 | 92,199.07 |
| **33** | **АВЛАГА** | 123,268,040.78 | 43,821,501.53 |
| 33100 | Ажиллагчидтай холбогдсон авлага | 1,509,462.00 | 1,509,462.00 |
| 33200 | Төлбөртэй үйлчилгээний авлага | 121,758,578.78 | 42,312,039.53 |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | 65,639,293.28 | 56,009,798.48 |
| **351** | **Түүхий эд материал** | 62,672,086.28 | 49,285,341.48 |
| 35130 | Эм боох материал | 62,672,086.28 | 49,285,341.48 |
| **354** | **Хангамжийн материал** | 2,967,207.00 | 6,724,457.00 |
| 35410 | Бичиг хэргийн материал | 162,000.00 | 00.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 2,438,407.00 | 4,059,907.00 |
| 35460 | Хүнсний материал | 366,800.00 | 2,664,550.00 |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **1,777,245,645.66** | **1,681,313,331.12** |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | 1,777,245,645.66 | 1,681,313,331.12 |
| **392** | **Биет хөрөнгө** | 1,756,631,645.66 | 1,660,776,331.12 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 1,623,295,651.85 | 1,623,295,651.85 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | -309,181,585.94 | -340,259,102.96 |
| 39203 | Авто-тээврийн хэрэгсэл | 351,672,714.00 | 313,132,714.00 |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл | -104,608,809.54 | -129,103,923.70 |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 404,696,165.96 | 471,977,295.06 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | -232,214,491.11 | -295,853,470.33 |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 67,577,233.40 | 64,328,358.40 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | -44,605,232.96 | -46,741,191.20 |
| 39214 | Бусад үндсэн хөрөнгө | 5,434,940.00 | 5,434,940.00 |
| 39215 | Хуримтлагдсан элэгдэл | -5,434,940.00 | -5,434,940.00 |
| **393** | **Биет бус хөрөнгө** | 20,614,000.00 | 20,537,000.00 |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 21,274,000.00 | 21,274,000.00 |
| 39304 | Хуримтлагдсан элэгдэл | -660,000.00 | -737,000.00 |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **1,997,578,040.68** | **1,781,236,830.20** |
| **4** | **НИЙТ ӨР ТӨЛБӨР** | **173,370,619.36** | **146,607,857.39** |
| **41** | **БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР** | 173,370,619.36 | 146,607,857.39 |
| **413** | **Өглөг** | 173,370,619.36 | 146,607,857.39 |
| 41310 | Ажилчидтай холбогдсон өглөг | 134,777,723.36 | 101,114,284.02 |
| **4136** | **Бусад өглөг** | 38,592,896.00 | 45,493,573.37 |
| 41361 | Байгууллагад төлөх өглөг | 32,094,896.00 | 45,493,573.37 |
| 41362 | Хувь хүмүүст төлөх өглөг | 6,498,000.00 | 00.00 |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **1,824,207,421.32** | **1,634,628,972.81** |
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | 1,824,207,421.32 | 1,634,628,972.81 |

| | | | |
|---|---|---|---|
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 312,334,144.45 | 312,334,144.45 |
| 51101 | Өмч: - төрийн | 312,334,144.45 | 312,334,144.45 |
| **512** | **Хуримтлагдсан үр дүн** | 791,480,533.55 | 612,916,085.04 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | 791,480,533.55 | 802,494,533.55 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | 00.00 | -189,578,448.51 |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 720,392,743.32 | 709,378,743.32 |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **1,997,578,040.68** | **1,781,236,830.20** |

## 2.2 АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

/төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **1,725,448,479.17** | **1,684,357,217.24** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **321,193,566.40** | **72,188,574.94** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 321,193,566.40 | 72,188,574.94 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 321,193,566.40 | 72,188,574.94 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 31,970,000.00 | 4,740,000.00 |
| 1200045 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого | 00.00 | 15,307,665.84 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **1,404,254,912.77** | **1,612,168,642.30** |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 79,119,100.00 | 59,656,100.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 79,119,100.00 | 59,656,100.00 |
| **1340** | **Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих** | 1,325,135,812.77 | 1,552,512,542.30 |
| 134002 | Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих | 1,325,135,812.77 | 1,552,512,542.30 |
| **2** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **1,559,955,731.96** | **1,871,310,665.75** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **1,559,955,731.96** | **1,871,310,665.75** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 1,559,955,649.70 | 1,871,310,665.75 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 1,007,914,867.51 | 1,205,642,867.55 |
| 210101 | Үндсэн цалин | 603,024,345.14 | 784,299,727.85 |
| 210102 | Нэмэгдэл | 344,889,026.27 | 373,133,100.99 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 24,771,015.85 | 31,217,698.71 |
| 210104 | Урамшуулал | 35,230,480.25 | 16,992,340.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 114,825,172.61 | 157,137,294.55 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 92,513,672.61 | 103,829,635.68 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 5,578,900.00 | 12,215,251.22 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 2,789,300.00 | 13,355,676.22 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 2,789,300.00 | 5,547,346.29 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 11,154,000.00 | 22,189,385.14 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 84,204,433.74 | 79,923,673.21 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 7,369,694.06 | 7,678,500.00 |
| 210302 | Түлш, халаалт | 72,205,920.26 | 66,673,173.21 |

| | | | |
|---|---|---|---|
| 210303 | Цэвэр, бохир ус | 4,628,819.42 | 5,572,000.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 68,375,570.00 | 81,351,650.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 3,993,150.00 | 4,657,750.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 51,894,220.00 | 63,270,430.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 2,529,700.00 | 3,068,000.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 3,517,000.00 | 2,885,370.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 6,441,500.00 | 7,470,100.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 138,559,329.84 | 152,380,676.80 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 126,631,603.84 | 124,649,426.80 |
| 210502 | Хоол, хүнс | 11,927,726.00 | 18,011,250.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 00.00 | 9,720,000.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 5,888,500.00 | 10,407,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 5,888,500.00 | 10,407,000.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 6,882,000.00 | 1,440,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 6,882,000.00 | 1,440,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 2,796,917.00 | 7,629,280.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 180,000.00 | 4,826,226.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 684,000.00 | 806,400.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 278,250.00 | 389,259.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 161,207.00 | 557,935.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 1,294,000.00 | 850,000.00 |
| 210807 | Газрын төлбөр | 199,460.00 | 199,460.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 130,508,859.00 | 175,398,223.64 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 4,387,300.00 | 00.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 126,121,559.00 | 175,398,223.64 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)** | **165,492,747.21** | **-186,953,448.51** |
| **225** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН** | 00.00 | 2,625,000.00 |
| 225001 | Үндсэн хөрөнгө худалдсаны гарз | 00.00 | 2,625,000.00 |
| **4** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)** | 00.00 | -2,625,000.00 |
| **5** | **НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)** | **165,492,747.21** | **-189,578,448.51** |

## 2.3 АУДИТ ХИЙСЭН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

**/төгрөгөөр/**

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | | |
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)** | **1,332,137,330.99** | **1,696,355,181.55** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **31,970,000.00** | **4,740,000.00** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 31,970,000.00 | 4,740,000.00 |
| 120004 | **Төсөв байгууллагын өөрийн орлого** | 31,970,000.00 | 4,740,000.00 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 31,970,000.00 | 4,740,000.00 |

| | | | |
|---|---|---|---|
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **1,300,167,330.99** | **1,691,615,181.55** |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 79,119,100.00 | 59,656,100.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 79,119,100.00 | 59,656,100.00 |
| **1340** | **Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих** | 1,221,048,230.99 | 1,631,959,081.55 |
| 134002 | Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих | 1,221,048,230.99 | 1,631,959,081.55 |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)** | **1,301,465,167.76** | **1,697,738,043.44** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **1,301,465,167.76** | **1,697,738,043.44** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **1,301,465,085.50** | **1,697,738,043.44** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 959,581,531.76 | 1,173,479,201.44 |
| 210101 | Үндсэн цалин | 554,691,009.39 | 710,241,489.77 |
| 210102 | Нэмэгдэл | 344,889,026.27 | 391,189,172.96 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 24,771,015.85 | 31,217,698.71 |
| 210104 | Урамшуулал | 35,230,480.25 | 40,830,840.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 58,888,727.00 | 222,964,400.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 36,577,227.00 | 180,201,300.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 5,578,900.00 | 10,691,000.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 2,789,300.00 | 5,345,000.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 2,789,300.00 | 5,345,000.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 11,154,000.00 | 21,382,100.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 78,619,017.74 | 59,206,100.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 7,369,694.06 | 7,678,500.00 |
| 210302 | Түлш, халаалт | 66,620,504.26 | 45,955,600.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 4,628,819.42 | 5,572,000.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 69,166,960.00 | 77,670,640.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 4,155,150.00 | 4,376,250.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 53,337,110.00 | 61,357,520.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 2,529,700.00 | 3,068,000.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 2,516,000.00 | 2,456,370.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 6,629,000.00 | 6,412,500.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 100,007,432.00 | 136,899,122.00 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 88,120,932.00 | 103,830,522.00 |
| 210502 | Хоол, хүнс | 11,886,500.00 | 20,348,600.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 00.00 | 12,720,000.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 5,888,500.00 | 10,526,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 5,888,500.00 | 10,526,000.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 3,790,000.00 | 7,938,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 3,790,000.00 | 7,938,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 22,560,917.00 | 7,629,280.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 19,944,000.00 | 4,826,226.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 684,000.00 | 806,400.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 278,250.00 | 389,259.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 161,207.00 | 557,935.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 1,294,000.00 | 850,000.00 |
| 210807 | Газрын төлбөр | 199,460.00 | 199,460.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 2,962,000.00 | 1,425,300.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 2,962,000.00 | 1,425,300.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **82.26** | **00.00** |
| **2134** | **Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт** | 82.26 | 00.00 |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 82.26 | 00.00 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)** | **30,672,163.23** | **-1,382,861.89** |
| **5** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)** | **00.00** | **29,950,000.00** |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **00.00** | **29,950,000.00** |
| **2200** | **Дотоод эх үүсвэрээр** | 00.00 | 29,950,000.00 |
| 225106 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | 00.00 | 29,950,000.00 |
| **6** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)** | **00.00** | **-29,950,000.00** |
| **8** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)** | 30,672,163.23 | -31,332,861.89 |
| **9** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | 752,897.73 | 31,425,060.96 |
| **10** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | 31,425,060.96 | 92,199.07 |

## 2.4 АУДИТ ХИЙСЭН ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

/төгрөгөөр/

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Бусад | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн |
|---|---|---|---|---|---|---|
| C01 | **2024 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл** | 312,334,144.45 | 786,874,743.32 | 808,494,521.99 | 00.00 | 1,907,703,409.76 |
| C02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | 00.00 | 00.00 | 42,952,000.00 | 00.00 | 42,952,000.00 |
| C03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **312,334,144.45** | **786,874,743.32** | **851,446,521.99** | **00.00** | 1,950,655,409.76 |
| C04 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| C05 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| C06 | Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| C07 | Тайлант үсийн үр дүн | 00.00 | 00.00 | -36,481,890.59 | 00.00 | -36,481,890.59 |
| C08 | **2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **312,334,144.45** | **720,392,743.32** | **791,480,533.55** | **00.00** | 1,824,207,421.32 |
| D01 | **2025 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл** | **312,334,144.45** | **720,392,743.32** | **791,480,533.55** | **00.00** | 1,824,207,421.32 |
| D02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | 00.00 | 00.00 | 11,014,000.00 | 00.00 | 11,014,000.00 |
| D03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **312,334,144.45** | **720,392,743.32** | **802,494,533.55** | **00.00** | 1,835,221,421.32 |
| D04 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт | 00.00 | -11,014,000.00 | 00.00 | 00.00 | -11,014,000.00 |
| D05 | Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| D06 | Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| D07 | Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| D08 | Тайлант үеийн үр дүн | 00.00 | 00.00 | -189,578,448.51 | 00.00 | -189,578,448.51 |
| D09 | **2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **312,334,144.45** | **709,378,743.32** | **612,916,085.04** | **00.00** | 1,634,628,972.81 |

## 2.5 АУДИТ ХИЙСЭН ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

/төгрөгөөр/

| Эдийн засгийн ангилал | Үзүүлэлт | Тайлант оны | |
|---|---|---|---|
| | | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл |
| 1 | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | |
| 2 | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | 1,755,417,600.00 | 1,668,031,943.44 |
| 21 | **УРСГАЛ ЗАРДАЛ** | 1,755,417,600.00 | 1,668,031,943.44 |

| | | | |
|---|---|---|---|
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 1,755,417,600.00 | 1,668,031,943.44 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 1,236,147,700.00 | 1,173,479,201.44 |
| 210101 | Үндсэн цалин | 841,629,800.00 | 710,241,489.77 |
| 210102 | Нэмэгдэл | 242,818,200.00 | 391,189,172.96 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 13,422,300.00 | 31,217,698.71 |
| 210104 | Урамшуулал | 138,277,400.00 | 40,830,840.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 237,588,700.00 | 222,964,400.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 185,979,900.00 | 180,201,300.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 12,902,200.00 | 10,691,000.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 6,451,100.00 | 5,345,000.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 6,451,100.00 | 5,345,000.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 25,804,400.00 | 21,382,100.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 77,981,700.00 | 77,670,640.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 4,383,600.00 | 4,376,250.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 61,358,300.00 | 61,357,520.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 3,223,700.00 | 3,068,000.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 2,516,100.00 | 2,456,370.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 6,500,000.00 | 6,412,500.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 142,897,800.00 | 136,899,122.00 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 108,996,200.00 | 103,830,522.00 |
| 210502 | Хоол, хүнс | 20,901,600.00 | 20,348,600.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 13,000,000.00 | 12,720,000.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 40,835,000.00 | 40,026,000.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 29,970,000.00 | 29,950,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 10,865,000.00 | 10,076,000.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 8,050,900.00 | 7,938,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 8,050,900.00 | 7,938,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 9,977,700.00 | 7,629,280.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 6,566,300.00 | 4,826,226.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 806,400.00 | 806,400.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 593,600.00 | 389,259.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 600,000.00 | 557,935.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 150,000.00 | 00.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 861,400.00 | 850,000.00 |
| 210807 | Газрын төлбөр | 400,000.00 | 199,460.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 1938100.00 | 1425300.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 1,938,100.00 | 1,425,300.00 |
| | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 1,755,417,600.00 | 1,636,699,081.55 |
| **1340** | **НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | 1,719,253,400.00 | 1,631,959,081.55 |
| 134002 | Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих | 1,719,253,400.00 | 1,631,959,081.55 |
| **120004** | **ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС** | 36,164,200.00 | 4,740,000.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 4,740,000.00 | 4,740,000.00 |
| 1200043 | Урьд оны үлдэгдлээс санхүүжих | 31,424,200.00 | 00.00 |
| **4** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | 00.00 | 31,425,060.96 |
| **5** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | 00.00 | 92,199.07 |
| **61** | **БАЙГУУЛЛАГЫН ТОО** | 1.00 | 1.00 |
| 610001 | Төсвийн байгууллага | 1.00 | 1.00 |
| **62** | **АЖИЛЛАГСАДЫН ТОО** | 50.00 | 46.00 |
| 620001 | Удирдах ажилтан | 1.00 | 1.00 |
| 620002 | Гүйцэтгэх ажилтан | 28.00 | 24.00 |
| 620003 | Үйлчлэх ажилтан | 21.00 | 21.00 |

## 2.6 АУДИТ ХИЙСЭН ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

/төгрөгөөр/

| Код | Үзүүлэлт | Төлөвлөгөө | Төсвийн гүйцэтгэлийн тайлан | Гүйцэтгэл зөрүү | Хувь |
|---|---|---|---|---|---|
| **1** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | | | |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **59,656,100.00** | **59,656,100.00** | | **100%** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **59,656,100.00** | **59,656,100.00** | | **100%** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **59,656,100.00** | **59,656,100.0** | | **100%** |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | **59,206,100.00** | **59,206,100.00** | | **100%** |
| 210301 | Гэрэл цахилгаан | 7,678,500.00 | 7,678,500.00 | | 100% |
| 210302 | Түлш, халаалт | 45,955,600.00 | 45,955,600.00 | | 100% |
| 210303 | Цэвэр, бохир ус | 5,572,000.00 | 5,572,000.00 | | 100% |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | **450,000.00** | **450,000.00** | | **100%** |
| 210604 | Урсгал засвар | 450,000.00 | 450,000.00 | | 100% |
| | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | **59,656,100.00** | **59,656,100.00** | | **100%** |
| **1310** | **ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | **59,656,100.00** | **59,656,100.00** | | **100%** |
| 132001 | Орон нутгийн төсвөөс | 59,656,100.00 | 59,656,100.00 | | 100% |
| **62** | **АЖИЛЛАГСАДЫН ТОО** | **50.00** | **46.00** | | **100%** |
| 620001 | Удирдах ажилтан | 1.00 | 1.00 | | 100% |
| 620002 | Гүйцэтгэх ажилтан | **28.00** | **24.00** | | **100%** |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 620003 | Үйлчлэх ажилтан | 21.00 | 21.00 | | 100% |

## 3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

### 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Эмнэлгийн тусламж үйлчилгээ болон нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээг хүн амд тэгш хүртээмжтэй чанартай хүргэн, хүн эрүүл аюулгүй орчинд ажиллаж амьдарах таатай орчин бүрдүүлэх нь бидний зорилго.

### 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тэс сумын Эрүүл мэндийн төвийн удирдлага төсвийн шууд захирагчийн хувьд дараах хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын хүрээнд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна. Үүнд

- Эрүүл мэндийн тухай хууль
- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ хадалдан авах тухай хууль
- Хэмнэлтийн тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Татварын тухай хууль
- Нийгмийн даатгалын тухай хууль

Тайлант хугацаанд санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлтүүд орсон байна. Үүнд:

- ✓ Нийгмийн даатгалын ерөнхий хууль  2025 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс мөрдөгдсөн
- ✓ Төрийн албаны  тухай хуульд 2023 оны 01 дүгээр сарын 06-ны өдөр, 05 дугаар сарын 04-ний өдөр,06 дугаар сарын 16-ны өдөр, 07 дугаар сарын 07-ны өдөр, 11 дүгээр сарын 10-ны өдөр, 12 дугаар сарын 07-ны өдөр ,2025 оны 06 дугаар сарын 05-ны өдөр
- ✓ Хөдөлмөр ,нийгмийн түншлэлийн гурван талт үндэсний хорооны 2024 оны 10 дугаар сарын 07-ны 3 дугаар тогтоолоор улсын хэмжээнд мөрдөх хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 2025 оны 04 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн сард 792.0 мянган төгрөгөөр шинэчлэн тогтоосон.
- ✓ Сангийн сайдын 2025 оны 01 дүгээр сарын 05-ны өдрийн А/3 дугаар тогтоолоор батлагдсан "Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам"
- ✓ Засгийн газрын 2024 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн 238 дугаар тогтоолоор
- ✓ Төрийн болон орон нутгийн өмчийн бараа ажил үйлчилгээ худалдаа авах тухай хуульд 2025 оны 06 дугаар сарын 05-ны өдөр тус тус шинэчлэн тогтоосон байна.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Тэс сумын Эрүүл мэндийн төвийн 2025 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Мөн төсвийн гүйцэтгэлийн тайланг Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.5-д заасны дагуу бүрэлдэхүүн хэсгээр иж бүрэн бэлтгэж ирүүлсэн байна.

### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Тэс сумын Эрүүл мэндийн төвийн 2025 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2025 оны 03 дугаар тушаалаар баталсан "Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам"-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 216,341.2 мянган төгрөгөөр буюу 10.8 хувиар буурсан байна.

*Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт*

/мянган төгрөгөөр/

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
|---|---|---|---|
| Б | 1 | 2 | 3=2-1 |
| Мөнгөн хөрөнгө | 31,425.0 | 92.2 | -31,332.8 |
| Авлага | 123,268.0 | 43,821.5 | -79,446.5 |
| Бараа материал | 65,639.2 | 56,009.8 | -9,629.4 |
| Үндсэн хөрөнгө | 1,777,245.6 | 1,681,313.3 | -9,923.3 |
| **Нийт хөрөнгө** | **1,997,578.0** | **1,781.236.8** | **-216,341.2** |
| Өр төлбөр | 173,370.6 | 146,607.8 | -26.762.8 |
| Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/ | 1,822,207.4 | 1,634,628.9 | -18,578.5 |
| **Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн** | **1,997,578.0** | **1,781,236.8** | **-216,341.2** |

Төрийн сан дахь харилцах дансны үлдэгдэл нь өмнөх оны үзүүлэлтээс 31,332.8 мянган төгрөгөөр буурсан байна.

Авлага дансны үлдэгдэл 43,821.5 болж 79,446.5 мянган төгрөгөөр буурсан нь эрүүл мэндийн даатгалаас авах санхүүжилтын авлага буурчээ.

Бараа материалын дансны үлдэгдэл 56,009.8 мянган төгрөг болж 9,629.4 мянган төгрөгөөр буурсан нь эм боох бараа, материалын оны эхний үлдэгдлээс зарлагадсан байна. Бараа материал дансны үлдэгдэлд худалдаж авсан ашиглалтгүй бараа материал байхгүй болно.

Өр төлбөр дансны үлдэгдэл 146,607.8 мянган төгрөг болж 26,762.8 мянган төгрөгөөр буурсан нийгмийн даатгалд төлөх шимтгэлийн өглөг буурсан байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 1,681,313.3 мянган төгрөг болж, 9,923.3 мянган төгрөгөөр буурсан нь элэгдлийн зардал өссөнтэй холбоотой байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 1,634,628.9 мянган төгрөг болж 18,578.5 мянган төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үр дүн.

### 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

### 3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2025 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг эрүүл мэндийн даатгалын сангаас 1,668,854.4 мянга, орон нутгийн төсвөөс 55,400.0 мянга, нийт 1,724,254.4 мянган төгргөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчид хүргүүлсэн төсвийн төслөөс эрүүл мэндийн даатгалын санхүүжилтийг 90,819.3 мянган төгрөгөөр бууруулж баталжээ.

### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 4 арга хэмжээг санхүүжүүлэхээр эрүүл мэндийн датгалын сангаас 1,346,310.9 мянга, орон нутгийн төсвөөс 74,547.5 мянга, нийт 1,420,858.4 мянган төгрөгөөр санхүүжүүлэхээр төсөвлөжээ.

Гүйцэтгэлээр эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих 1,631,959.2 мянга, туслах үйл ажиллагааны орлогоос 4,740.0 мянга, оны эхний үлдэгдэлээс 31,424.2 мянга, нийт 1,668,123.3 мянган төгрөгийн санхүүжилт бүрдүүлж, урсгал үйл ажиллагааны зардалд 1,668,031.9 мянган төгрөгийг зарцуулж 91.2 мянган төгрөгийн мөнгөн хөрөнгийн эцсийн үлдэгдэлтэй байна.

Орон нутгийн төсвөөс гүйцэтгэлээр 59,656.1 мянган төгрөгийн төсөв бүрдүүлж түлш халаалтын зардалд 45,955.6 мянга, гэрэл цахилгааны зардалд 7,678.5 мянга, цэвэр бохир усны зардалд 5,572.0 мянга, урсгал засварын зардалд 450.0 мянган төгрөгийг тус тус зарцуулжээ.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1,727,688.0 мянган төгрөг буюу 93.5 хувьтай байгаа нь цалин хөлс болон нэмэгдэл урамшууллын зардлыг 62,385.5 мянга, ажил олгогчоос төлөх нийгмийн даатгалын шимтгэл 14,624.3 мянга, нормативт зардлыг 5,998.7 мянга, бараа үйлчилгээний бусад зардал 512.8 мянган төгрөгөөр тус тус дутуу зарцуулсантай холбоотой байна.

*Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл*

/мянган төгрөгөөр/

| д/д | Хөтөлбөр, арга хэмжээ | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Биелэлт |
|---|---|---|---|---|---|
| 1 | Нэг иргэнд ногдох нормативаар | 1,286,065.2 | 1,244,006.8 | 42,058.3 | 96.7% |
| 2 | Үндсэн мэргэжлийн тусламж үйлчилгээ | 308,929.6 | 266,193.6 | 42,735.9 | 86.1% |
| 3 | Дээд шатны төсвөөс хуваарилсан | 121,758.6 | 121,758.6 | 0 | 100% |
| 4 | Туслах үйл ажиллагааны зардал | 2,490.0 | 2,490.0 | 0 | 100% |

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т "Нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна" гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй. Тэс сумын Эрүүл мэндийн төвийн нэмэлт санхүүжилтийн дансаар орлого, зарлага гараагүй байна.

### 3.5.3 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Тэс сумын Эрүүл мэндийн төвийн тайлант онд хэрэгжүүлсэн төсөл хөтөлбөр байхгүй байна.

### 3.5.4 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Тэс сумын Эрүүл мэндийн төвийн 2025 онд 20,901.6 мянган төгрөгийн төсөвт өртөгтэй хоол хүнсний материалыг шууд худалдан авалтын гэрээ хийж хувь хүнээс мах, сүүн бүтээгдэхүүн, "Бадрал тэс" хоршоо, "Ягаан толгой" ххк-тай хүнсний бүтээгдэхүүнүүдийг тус тус нийлүүлэхээр гэрээ хийж худалдан авалт хийжээ.

## 4. АУДИТЫН ТАЙЛАН

### 4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д "Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана" гэж заасны дагуу Тэс сумын Эрүүл мэндийн төвийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Баян жанжин хишиг аудит ХХК-ийн аудитор А.Дугармаа гүйцэтгэж, хяналтыг Увс аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Б.Нямбуу, аудитын менежер М.Бат-Амгалан, дарга, тэргүүлэх аудитор М.Батсуурь нар тус тус хэрэгжүүлсэн.

Тэс сумын Эрүүл мэндийн төвийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Баян жанжин хишиг аудит ХХК-д 2026 оны 01 дүгээр сарын 20-ний өдрийн 03 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

### 4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон материаллаг байдлыг 2024 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 1,480,836.6 мянган төгрөгөөс 1

хувиар буюу 14,808.3 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагатай гэж үзсэн.

Гүйцэтгэлийн шатанд материаллаг байдлыг 2025 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 1,871,310.6 мянган төгрөгийн 1 хувиар буюу 18,713.1 мянган төгрөгөөс 80 хувиар тооцож 14,970.0 мянган төгрөгөөр тогтоолоо.

**4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт**

Тэс сумын Эрүүл мэндийн төвийн хувьд Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хамаарах зүйл заалтын хүрээнд горим сорил хэрэгжүүлсэн.

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил гараагүй болно. /АБ-4/

**4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

**4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд www.shilendans.gov.mn цахим хуудсанд оруулбал зохих 171 мэдээллээс байршуулах хугацаа болоогүй 2, хугацаандаа оруулсан 144, хугацаа хоцроож 25 мэдээллийг шилэн дансны цахим хуудсанд байршуулсан байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

**4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд**

Төрийн аудитын байгууллагаас 2025-2026 онд гүйцэтгэх санхүүгийн тайлангийн аудитаар баримтлах ерөнхий чиглэлд тусгагдсан болон бусад хууль тогтоомжтой холбоотой хэрэгжүүлсэн горим сорилын хүрээнд зөрчил илрээгүй болно.

**4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт**

Тэс сумын Эрүүл мэндийн төвийн 2025 оны санхүүгийн тайланд завсрын аудит хийгээгүй болно.

**4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн**

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар зөвлөмж өгөөгүй байна.

**4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал**

Тэс сумын Эрүүл мэндийн төвийн хувьд дараагийн аудитаар анхаарах асуудал байхгүй болно.

## 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 2,960.0 мянган төгрөгийн зөрчил илэрснээс зөрчлийг давтан гаргахгүй байх 1 зөвлөмж өглөө.

5.1 Жолоочийн замын хуудасны тооцоо бодолттой холбоотой асуудал

Илрүүлэлт:

Тэс сумын Эрүүл мэндийн төв нь 800.0 литр буюу 2,960.0 мянган төгрөгийн АИ-92 бензинийг баталгаажаагүй жолоочийн замын хуудсаар тооцоо бодож зарлагын гүйлгээ хийж тайлагнасан.

**Өгсөн зөвлөмж:**

Зам тээврийн сайдын 2019 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн 390 дугаар тушаалын 1 дүгээр хавсралт, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д "Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлийн дараах зарчмыг баримтална", 13 дугаар зүйлийн 13.5-д "Анхан шатны баримтад түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн буюу шалгасан ажилтан гарын үсэг зурж, тамга ,тэмдэг дарснаар уг баримт хүчин төгөлдөр болно" гэж заасныг мөрдлөг болгон ажиллах.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

**Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

| Алдааны товч утга | Нийт алдаа | | Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан | | Буруу тусган илэрхийлсэн | | Үүнээс | | | | Зөвлөмж | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Залруулсан | | Залруулаагүй | | | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| | | | | | | | | | | | | |
| | | | | | | | | | | | | |

**Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | | Хариуцлага тооцуулах албан шаардлага | | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал | |
| | Тоо | Дүн | То о | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Албан тушаалтны тоо | Тоо | Дүн |
| Баталгаажаагүй замын хуудсаар АИ 92 бензин зарлагадсан | 1 | 2,960.0 | | | | | 1 | 2,960.0 | | | | |
| | | | | | | | | | | | | |
| Дүн | 1 | 2,960.0 | | | | | 1 | 2,960.0 | | | | |

**Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил | | | | | | | | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | |
| | | | | | | | | |
| Дүн | | | | | | | | |
| Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил | | | | | | | | |
| | | | | | | | | |
| | | | | | | | | |
| Дүн | | | | | | | | |
| Нийт дүн | | | | | | | | |

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

<u>АУДИТЫН ТАЙЛАНГ</u>

ХЯНАСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР /М.БАТСУУРЬ/

АУДИТЫН МЕНЕЖЕР /М.БАТ-АМГАЛАН/

БЭЛТГЭСЭН: БАЯН ЖАНЖИН ХИШИГ АУДИТ
ХХК-ийн ЗАХИРАЛ, АУДИТОР /А.ДУГАРМАА/

2026 оны 02 дугаар сарын 14-ний өдөр